

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр, Даваа гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-20

1.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 4-12

2.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 13-20

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
2024 оны 01 дугаар сарын 15-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 18 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: Ц.Даваасүрэн;
Чөлөөтэй: Г.Тэмүүлэн, Ц.Анандбазар, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Б.Жавхлан,
Л.Мөнхбаатар, С.Одонтуяа.*

Нэг.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ш.Раднаасэд нарын тавьсан асуултад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан нар хариулж, тайлбар хийв.

Д.Тогтохсүрэн: Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын газрын дарга О.Номинчимэг, Нийслэлийн Засаг даргын “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн зохицуулагч М.Говьсайхан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Д.Өнөрболор, Д.Тогтохсүрэн нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат нар хариулж, тайлбар хийв.

Д.Тогтохсүрэн: Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 57 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 12 цаг 15 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
11 цаг 18 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Тогтохсүрэн: Төсвийн байнгын хорооны гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Байнгын хороон дарга хөдөө томилоттой ажиллаж байгаа учраас намайг Байнгын хороо удирдаач гэж хүссэн. Түүний дагуу Байнгын хорооны хурлыг удирдаж явуулъя.

Байнгын хорооны хуралд ирсэн Байнгын хорооны гишүүдийг танилцуулъя.

Ганибалын Амартүвшин гишүүн ирсэн байна. Хавдисламын Баделхан гишүүн ирсэн байна. Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн ирсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн байна. Шадарбалын Раднаасэд гишүүн ирсэн байна. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн байна. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн ирсэн байна. Чимэдийн Хүрэлбаатар гишүүн ирсэн байна. Баттогтохын Чойжилсүрэн гишүүн ирсэн байна.

Ингээд 19 гишүүнээс одоогийн байдлаар 10 гишүүн хүрэлцэн ирж, хурлын ирц 52.6 хувьтай болсон тул Төсвийн байнгын хорооны 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хурал нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн Байнгын хорооны хурлаар хоёр асуудал хэлэлцэнэ. Нийт Байнгын хорооны хуралдааны

төлөвлөгөөнд 5 асуудал хэлэлцэхээр байгаа.

Үүн дотроос Байнгын хорооны тогтоолын төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Үндэсний аудитын газрын тайлан хэлэлцэх гэсэн гурван асуудлыг Байнгын хорооны дарга оруулах учраас маргаашийн төсөв хорооны хурлаар хэлэлцүүлэхээр хойшлуулъя гэж бодож хойшлуулж байгаа. Хоёр асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газар 24 оны 1 сарын 11-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэхийг шийдэх асуудал байгаа.

Хоёрдугаарт нь Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төсөл, Засгийн газар 2024 оны 1 сарын 11-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх шийдэх ийм хоёр асуудлыг өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр оруулж байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлуудыг хэлэлцье.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Сайнбуяны Амарсайхан танилцуулна. Амарсайхан сайдыг урьж байна.

С.Амарсайхан: Эрхэм Байнгын хорооны дарга, Байнгын хорооны гишүүд ээ

Улсын Их Хурлаас 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төр

түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавих зохицуулалтыг хуульчилсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг бүх шатын төсвийн захирагчид, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд хангаж ажиллаж, хуулийн хэрэгжилтийн хүрээнд хэмнэгдэж байгаа зардал болон өдөр тутмын үйл ажиллагаанаас хэмнэх боломжтой зардлуудыг бууруулан хэмнэлт гаргасан байна.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн аудитын тайланд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд 83.2 тэрбум төгрөг нь хэмнэгдсэн байна гэж дурдаад Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээр төсвийг арвилан хэмнэлт, үр ашигтай зарцуулах эрх зүйн орчин бүрдсэнээр төсвийн алдагдал буурах, төрийн өмчит байгууллагуудын ашигт үйл ажиллагаа нэмэгдэх, үр дүн гарах боломжийг бий болгосон байна гэж дүгнэжээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хэмнэлтийн горим баталж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дагавар нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүй байхаар, төрийн үйл ажиллагаа үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байхаар тус тус заасан хэдий ч орон нутаг дахь төсвийн байгууллагууд, газар нутгийн хэмжээ, алслагдсан байдал, хүн амын тархмал суурьшил зэргээс шалтгаалан хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд харилцан адилгүй хүндрэл үүсэж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх боломж хязгаарлагдаж, төрийн үйлчилгээний чанар хүртээмж буурах, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах нөхцөл үүсээд байгаа талаар

төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудаас удаа дараа санал, хүсэлт ирүүлж байна.

Иймд орон нутаг дахь төсвийн байгууллага хэвийн үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан танилцуулж байна

Хуулийн төсөлд дараах өөрчлөлтийг тусгалаа. Үүнд:

Нэгдүгээрт, Төрийн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлж байгаа чиг үүрэгтэй аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, аймаг, сумын Засаг даргын Тамгын газар болон төрийн аудитын байгууллага, хяналт шалгалт хийх чиг үүргийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх хүрээнд эдгээр байгууллага автомашин ашиглах, худалдан авах зохицуулалтыг тусгасан.

2. Албан ажлын онцлогийг харгалзан иуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн албан хаагчийн албаны гар утасны зардлыг санхүүжүүлэх зохицуулалтыг мөн тусгалаа.

3. Сургалт, семинар, хурал зөвлөгөөний үр ашгийг нэмэгдүүлэх, оновчтой болгох зорилгоор Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3-д сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолтын зардлыг хориглосон зохицуулалтыг хуулиас хасахаар төсөлд тусгасан болно.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа Амарсайхан сайдад. Хуулийн төсөлтэй

холбогдуулж асуулт, санал хоёр тусдаа байгаа. Хуулийн төсөлтэй холбогдуулсан асуулт асуух гишүүдийн нэрс авъя. Асуулт асуух гэр гишүүд байна уу? Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн. Ажлын хэсэг.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр хоёр асуулт байгаад байгаа юм.

Нэгдүгээрт, тэр нийслэлээс алслагдсан гэдэг үг байгаад байгаа юм л даа. Тэгэхээр энэ аймгууд чинь бас нийтээрээ хамрагдахгүй байх юм уу? Энэ нийслэлтэйгээ ойрхон байгаа аймгууд нь яах юм гэдэг асуудал байна. Үүн дээр тодорхой хариу авъя гэж.

Хоёр дахь зүйл. Ноднин энэ хуулийг хэлэлцэж байх явцад эрүүл мэнд, байгаль орчин, зам тээврийн салбарын ажилтнуудын тэр ажлын болон дүрэмт хувцасны асуудлыг авч үлдсэн юм. Гэтэл дахиад хасахаар ороод иржээ. Энэ байгаль хамгаалагч нар гэдэг чинь үндсэндээ орон нутгийн иргэдээс бүрдсэн л ийм хамгаалалтын л үйл явц яваад байгаа шүү дээ. Баахан нударгатай дээлтэй иргэд байгаль орчны хамгаалалтын чиглэлээр иргэдтэй юм яриад явах юм уу, эс үгүй бол энэ улсын хэмжээнд энэ яах аргагүй байгаль орчны хамгаалалтын чиглэлээр чиг үүрэг хүлээсэн хүн байна гэдэг нь харагддаг тийм хувцастай байх ёстой юм биш үү л гэж үлдээсэн юм. Гэтэл дахиад хасахаар ороод ирсэн байх юм. Үүнийг ер нь юу гэж ойлгож хасахаар оруулж ирээд байна? Ийм 2 зүйл дээр хариулт аваадахъя.

Д.Тогтохсүрэн: Би эхлээд ажлын хэсгийг танилцуулъя.

Сайнбуяны Амарсайхан Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд, Барсүрэнгийн Баасандорж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга, Чулуунбаатарын Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Мижиддоржийн

Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Чойжилсүрэнгийн Ариунхур Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн ахлагч, Ганбатын Дөлгөөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч гэсэн ажлын хэсэг байна.

Саяын Батжаргал гишүүний асуултад хэн хариулт өгөх вэ? Санжаадорж дарга ажлын хэсгийн 3 номерын микрофон.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж, Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Автомашин дээр алслагдсан гэдэг үг орж ирсэн байгаа. Энэ нь ямар учиртай вэ гэхлээр Төрийн хэмнэлтийн тухай хууль дээр өөрчлөлт оруулах шаардлага байна уу, үгүй юү гэдэг дээр Ерөнхий сайдын захирамжаар бол ажлын хэсэг байгуулагдсан. Мөн яг автомашин дээр тусгайлан байгуулагдсан байгаа.

Автомашин дээр бол бид нар одоо байгууллагуудын нэрийн доор Засаг даргын Тамгын газрын харьяа байгууллагууд гэж нэмчхэж байгаа юм. Гэхдээ үүнийгээ бас хэт задгай тавихгүйгээр ямар хэмжээний байгууллагад ямар машин хэмжээний машин байх вэ гэдгийг бол тооцож гаргаж ирэхээр бол ажиллах юм байгаа юм дараачийн удаа.

Тэгэхлээр алслалтын байдлыг нь харж байж гэсэн үг. Жишээ нь Улаанбаатар хоттой бол хамгийн ойр аймаг Төв аймгийн хувьд бол алслалт нь хэд вэ, сумдын тоо нь хэд вэ, сумуудтайгаа засмал замаар холбогдсон хэмжээ нь хэд вэ, мөн төрийн үйлчилгээ хүргэх иргэдийн тоо маань хэд вэ гэдгээс шалтгаалж өөрөөр хэлбэл томьёо

гаргаж ирж энэ дээр автомашины тоог гаргаж ирэхээр одоо оруулсан юм.

Тийм учраас бол алслагдсан гэдэг бол тоо оруулж ирж байгаа. Төвийн бүх аймгууд бол хамрагдана. Хэмнэлтийн тухай хууль дээр бол 17 дугаар зүйлийн 2 дугаар заалт дээр нэг заалт байгаа. Тэр нь юу вэ гэхлээр энэ зургаадугаар зүйл буюу автомашинтай холбоотой нийтлэг журмыг Засгийн газар батална гэххэд байгаа юм. Тэгэхлээр энэ хууль батлагдсан тохиолдолд Засгийн газар дээрээ батлаад, ямар хэмжээний машиныг хэрхэн хэрэглэх вэ, том, жижиг нь ямар байх вэ, стандарт нь ямар байх вэ гэдэг байдлаар цаашидаа оруулж ирнэ гэсэн ийм байдлаар ажлын хэсэг дээр бол яригдсан байгаа.

Д.Тогтохсүрэн: Ажлын хэсгийн 4 номер Барсүрэнгийн Баасандорж. Ажлын хэсгийн 4 номерын микрофон. Ажлын хэсгийн 2 номер.

Б.Баасандорж: Гишүүний хоёр дахь асуултад хариулъя. Энэ гишүүний 8.2 дугаар зүйл маань өөрөө дүрэмт хувцас гэсэн зохицуулалт байгаа. Тэгэхээр энэ дүрэмт хувцас гэсэн зохицуулалт бол яг нөгөө дүрэмт хувцас, хуулиар дүрэмт хувцас өмсөхийг зөвшөөрсөн байгууллагууд л дүрэмт хувцсаа хэрэглэх юм. Жишээ нь дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай, цагдаа, шүүх гэх мэт. Таны саяын асуусан эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах энэ хүмүүсийг хасаж өгч байгаа нь өөрөө нээж өгч байгаа юм. Энэ Төрийн хэмнэлтийн хуулийн хязгаарлалтад орохгүй. Тэр тусгай хувцсаа эрүүл мэндийн байна уу, байгаль орчны байна уу тэр хүмүүс маань тусгай хувцсаа өөрөө хэрэглэх асуудлыг нь энэ дээр нээж өгч байгаа юм. Тийм учраас энэ дээр хасаж оруулж байгаа юм.

Д.Тогтохсүрэн: Батжаргал гишүүн тодруулга.

Ж.Батжаргал: Үгүй ээ үгүй. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн

нэгжүүд чиг үүргээ хэрэгжүүлэх үйл явцад нь яах аргагүй Хэмнэлтийн хуулиар хязгаарлалт үүсчхээд байна гээд үзээд өөрчлөлт оруулах гэж байгаа бол нийслэлээс алслагдсан байна уу, алслагдаагүй байна уу бүгд нэгжүүд нэг л чиг үүрэгтэй.

Тийм учраас одоо энд ийм байдлаар асуудалд хандаад байж болох юм уу? Алслагдсан аймгууд нь болохоор унаа унаш, элдэв бусын юмаараа хангагдаж болдог, алслагдаагүй нь болохоор хязгаарлалтад байдаг. Ийм байж болох юм уу? Үүн дээрээ тодорхой хариу өгөөч гэж. Наад 8.2 дахь зүйл чинь 8.1-тэйгээ холбогдож байгаа зүйл. Уг хуулийн заалтын үндсэн юу нь болохоор 8.1-д заасан гэж хэлж байгаа байхгүй юу. 8.1-д ийм ийм байгууллагуудын дүрэмт хувцас хэрэглэлийг нь зөвшөөрнө, бусдыг хязгаарлана гээд хэлчихсэн байхгүй юу. Гэтэл 8.1-д энэ хуулийн заалт хамаарахгүй ээ гээд.../минут дуусав./

Д.Тогтохсүрэн: Батжаргал гишүүний тэр алслагдсан гэдгийг аймаг, сумд ялгаа байхгүй шүү дээ. Тэр чинь алслагдсан, алслагдаагүй хамаагүй нэг л чиг үүрэг гүйцэтгэх байхгүй юу. Тэр чинь нийслэлээс ойрхон байдаг гээд унаагүй байна гэж болохгүй байхгүй юу. Адилхан л үүрэг гүйцэтгэнэ.

Тийм учраас тэрийг дараагийн хэлэлцүүлэг дээр саналын томьёолол хийгээд алслагдсан гэдэг үгээ хасаад явчхаж болох болов уу гэж бодоод л байна л даа.

Тэр хоёр дахь асуудал дээр хариулах юм уу Баасандорж дарга? Ажлын хэсгийн 2 номер.

Б.Баасандорж: Саяын алслагдсантай холбоотой ер нь 21 аймгууд ер нь бүгд энэ хамааралд орж байгаа. Сумууд нь сумуудаараа. Жишээ нь Төв аймаг орно шүү дээ. Алслагдсан самдуудаараа зарим сумууд нь алслагдсанаараа орно. Засаг даргын

дэргэд 26 агентлаг эрхлэх асуудлын хүрээнд нь хамаарч байгаа. Тэгэхээр энэ чиг үүргүүдээрээ Батжаргал гишүүнээ ер нь орж байгаа яг төсөл санаачлагчийн зүгээс үзэхдээ.

Таны хоёр дахь асуудал дээр энэ хөдөлмөр хамгааллын хувцас жишээ нь зарим салбаруудад ороогүй байгаа байхгүй юу. Зарим нь орчхоод, зарим нь ороогүй байгаа юм. Жишээ нь эрчим хүчний салбар ч гэдэг юм уу хөдөлмөр хамгааллын хувцас нь ороогүй. Тэгэхээр эндээс 8.2-оосоо хасаад өгчихөөр энэ 8-ын дүрэмт хувцас, 8.1 өөрөө хориглосон хязгаарлалт шүү дээ. Хориглосон хязгаарлалт байгаа юм. Энэ хориглолтоос нь аваад өгчихөөр энэ дүрэмт хувцас буюу тусгай хувцаснууд нь нээлттэй болж байгаа юм гишүүнээ. Эндээс авчихаар дутуу орхичихсон нэлээн хэд хэдэн бас салбарууд байгаа байхгүй юу. Тэгэхээр жигдлээд эндээс нь байгаль орчин, эрүүл мэндийг нь аваад өгчихөөр нийт ер нь дүрэмт, энэ тусгай хувцас хэрэглэдэг салбарууд маань энэ Төрийн хэмнэлтийн хуульд хамаарахгүйгээр ажлын хэрэгцээ шаардлагаасаа зохицуулаад энд хамаарахгүйгээр.../минут дуусав./

Д.Тогтохсүрэн: Хариулт өгөгдлөө. Одоо өөр байхгүй л дээ. Батжаргал гишүүнд дахиад 1 минут.

Ж.Батжаргал: Үгүй ээ үгүй, 8 дугаар зүйл чинь өөрөө ингээд байгаа байхгүй юу. 8.1 цэргийн албан хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно гэж хэлж байгаа юм.

Тэгээд 8.2 нь энэ хуулийн 8.1-д Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон шүүгч, эрүүл мэнд, байгаль орчин, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан хувцас хамаарахгүй гэж хэлсэн байхгүй юу. Хамаарахгүй гэсэн заалтаасаа энэ хэдийгээ авчихаар зэрэг

яаж эрх нь нээгддэг юм бэ энэ чинь? Үндсэндээ 8.1-дээ харьяалагдахаар болчихож байгаа байхгүй юу, хамрагдахаар. Ноднин үүнийг чинь яг ингэж ярьж байж энэ 3 нэр заагдсан байгууллагыг чинь хуульд авч үлдсэн байхгүй юу. Та хэд өөр талаас нь яриад.../минут дуусав./

Д.Тогтохсүрэн: Үүнийг 3 номер, 2 номер. Ажлын хэсгийн 2 номер Барсүрэнгийн Баасандорж.

Б.Баасандорж: Батжаргал гишүүн ээ харин яг таны яг концепт, таны хэлж байгаа саналын дагуу энэ 8 дугаар зүйл маань өөрөө дүрэмт хувцас, 8.1 дүрэмт хувцас хэрэглэхгүй байгууллагуудыг хориглож өгсөн. 8.1-д заасан Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон шүүгчийн өмсгөл өөрөө дүрэмт хувцас хуулиараа зохицуулдаг учраас үүнээс бусад хамаарахгүй шүү гэж өгөөд тэр тусгай хувцаснууд энд орчихсон байгаа байхгүй юу. Эрүүл мэнд, байгаль орчин хамгаалах, зам тээвэр гээд. Тусгай хувцас энэ зүйлд хамаарахгүй гэдэг зүйлийг бүүр тодотгож өгөхийн тулд эндээс нь хасаад өгчхөж байгаа юм.

Тэгэхээр таны хэлж байгаа саналууд эндээс хасагдсанаараа таны саналаа тэр тусгай хувцас хэрэглэдэг нь харин нээлттэй болж байгаа байхгүй юу гишүүн ээ. Дүрэмт хувцас, тусгай хувцас хоёрыг хольчихсон байгаа байхгүй юу 8.2 дээр.

Д.Тогтохсүрэн: Ойлголоо. Сандаг-Очир гишүүн. Сандаг-Очир гишүүний микрофон.

Ц.Сандаг-Очир: Өглөөний мэнд хүргэе. Төрийн хэмнэлтийн хуульд нэмэлт, өөрчлөлт орж байна. Ялт ч үгүй амьдралын үнэнд гүйцэгдээд л ингэж өөрчлөлт орж ирж байна л даа. Анхнаасаа хийхдээ сайн судлаагүй, амьдрал дээр ажил яаж явдгийг мэдэхгүй учраас хийчихсэн. Шуураад хийчихсэн.

Нэгд, Төрийн хэмнэлтийн хуулийн үр ашгийг тооцсон уу өнгөрсөн хугацаанд? 2 жил хэрэгжлээ. Та бүхний тооцоолж байснаар эхний ээлжид 22 оны сүүлийн хагаст 400 тэрбум төгрөгийн хэмнэлт үүснэ. 23 онд 1 их наяд төгрөгийн хэмнэлт үүснэ гэж ярьж байсан. Ийм хэмнэлт үүсэж чадсан уу, үгүй юү? Үр ашиг нь эерэг болон сөрөг нөлөөлөл нь юу байв? Магадгүй бас сөрөг үүссэн асуудлууд бий шүү дээ Хэмнэлтийн хуулиас болж. Энэ талыг дүгнэсэн зүйл байна уу гэдгийг нэгд асууя.

Хоёрт бас л дутуу орж ирж байна. Алсын 3 дүүргийг үнэхээр нийслэл Улаанбаатар хотоосоо алслагдсан аймгууд гэж байгаа юм бол алслагдсан 3 дүүргийг юу гэж үзэж байгаа юм? Өнөөдөр алсын 3 дүүргийн Тамгын газрыг машингүй болгочоод л байж байгаа юм. Мал тоо сая ингээд яваад өнгөрсөн. Машин олдохгүй, төрийн өмчийн компаниуд нь машинаа өгөхгүй. Энэ чинь яг анхан шатан дээр төрийн ажлыг яаж явуул гээд байгаа юм бэ? Бас л дутуу оруулж ирсэн байна. Үүнийгээ оруулахгүй юм уу? Алсын 3 дүүргийг Төрийн албаны хууль бусад энэ жилийн 24 оны олон хуулиуд дээр алслагдсан байдлыг нь харгалзаж хуулиуд дээр ялгаатай байдлаар оруулж ирж байгаа шүү дээ. Үүнийгээ Баасандорж дарга та одоо анзаарч харж, цаашидаа ер нь Засгийн газраас алслагдсантай холбоотой асуудлууд орж ирвэл энэ нийслэлийн 3 дүүргийг үүнийг нь одоо анзаарч үзэж байгаач. Үүнийг асууя.

Төрийн өмчийн компаниуд байгаа юм. Бас л асуудал хэвийн үйл ажиллагаа, дуудлага юманд явдаг. Жишээ нь Багануур зүүн өмнөд бүсийн “Цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК энэ зүүн аймаг болоод говийн аймгуудыг эрчим хүчний асуудлыг хариуцдаг, түгээлтийг хариуцдаг. Дандаа дуудлагад явдаг. Бас л нөгөө машин тэрэг хэвийн үйл ажиллагаа нь алдагдсан шүү дээ Хэмнэлтийн хуулиар. Бас л зовлон жаргал яриад л байсан очиж уулзахад. Зөвхөн төрийн байгууллагууд төсвийн байгууллагуудыг

өнөөдөр чөлөөлж оруулж ирж байгаа юм байна. Ийм үйлчилгээ явуулдаг төрийн өмчийн компаниудын асуудлыг яах юм. Ус, дулаан, эрчим хүчний энэ байгууллагуудын хэвийн үйл ажиллагаанд нь нөлөөлөөд байгаа шүү дээ. Энэ чинь зайлшгүй л төсвөөс гарах, үйлчилгээ үзүүлэх ёстой ийм л үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд шүү дээ.

Түүнээс төрийн өмч энэ хуулийн гол зорилго нь энэ төрийн өмчийн компаниуд дээр үүссэн хэрэгтэй хэрэггүй орон тоонуудыг, хүнд зориулсан орон тоонуудыг түүнийг дагасан туслах, жолооч машинуудыг хэмнэ л гэсэн ийм л агуулгатай байсан болохоос биш яг жинхэнээсээ үйлчилгээ үзүүлдэг энэ үйлчилгээнүүдийн хэвийн байдлыг алдагдуул гэж ерөөсөө яриагүй шүү дээ. Үүн дээр та бүхэн юу гэж хариулах юм? Ийм 3 асуултад хариулж өгөөч.

Д.Тогтохсүрэн: Баасандорж дарга уу? Баасандорж дарга ажлын хэсгийн 2 номер.

Б.Баасандорж: Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 4 сарын 29-ний өдөр батлагдсан. Энэ хуулийг Засгийн газраас оруулахдаа бас нэлээн тооцоо судалгаатай оруулсан гишүүн ээ. Тал талын тандалт судалгаа хийж, тооцоо судалгаатай оруулсан байгаа.

Тэгээд энэ хуулийн яг хэрэгжилт дээр Үндэсний аудитын газар хэрэгжилтэд нь үнэлгээ хийсэн байгаа, зөвлөмж гаргасан байгаа, дүгнэлт гаргасан байгаа. Жишээ нь Үндэсний аудитын газрын гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар батлагдсан эдийн засгийн ангиллаар Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах 2.7 тэрбум төгрөгийн урсгал зардлаас гүйцэтгэлээр 2.5 төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс 137 тэрбум төгрөг зарцуулагдаагүй байна.

Өөрөөр хэлбэл, аудитаар зарцуулагдаагүй үлдсэн 137 тэрбум төгрөгийг ангилахад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд 60.1 хувь буюу 83.1 тэрбум төгрөг нь хэмнэгдсэн байна гэдэг дүгнэлт аудитаас гарсан байгаа. Одоо 23 оных дээр ахиад аудитын дүгнэлт хийгдэж байгаа. Төрийн хэмнэлтийн тухай хууль гарснаараа өөрөө мөнгөөр хэмжигдэж болохоос гадна мөнгөн бусаар хэмжигдэж болохуйц маш олон хэмнэлтүүд гарсан.

Жишээ нь төрийн албан хаагчдын ерөнхийлөн захирагч, шууд захирагч нарын хандлага, төрийн албан хаагчийн ёс зүй, төсвийн сахилга бат гэх мэт нэлээдгүй хэмнэлтүүд гарсан гэж үзэж байгаа үр дүнд нь. Таны саяын хэлсэн төрийн өмчит компаниудын хувьд энэ Төрийн хэмнэлтийн тухай хууль гарснаас хойш Засгийн газраас бас зарим зарим хүндрэлтэй асуудал дээр шуурхай шуурхай арга хэмжээ авсны үндсэн дээр хэд хэдэн удаа өөрчлөлт оруулсан байгаа.

Жишээ нь 2023 оны 6 дугаар сарын 19-нд өөрчлөлт орсон Засгийн газраас өргөн мэдүүлээд. Үүн дээр 6.5.19 дээр үндсэн үйл ажиллагаа нь төрийн ёслолын болон шуурхай албаны тусгай зориулалтын авто тээврийн хэрэгсэл ашиглах хэрэгцээ шаардлагыг бий болгодог бусад байгууллагын тээврийн хэрэглэх асуудлыг нээж өгсөн. Энд таны саяын хэлж байгаа эрчим хүчний гэдэг юм уу төрийн өмчит компаниуд хамаарч байгаа. Яг энэ хэрэгцээ шаардлагуудыг нь бид нар судлаад, Засгийн газраас судлаад 6 сард өргөн мэдүүлээд өөрчлөлт оруулсан байгаа юм.

Саяын өөрчлөлтүүд дээр ч гэсэн бид нар яг төрийн аудитын байгууллагатайгаа хамтарсан хэлэлцүүлэг хийгээд, судалж үзээд нийт шууд захирагч болон ерөнхий захирагч нараасаа саналуудыг нь аваад Засаг дарга нартайгаа мөн хэлэлцүүлгүүдийг хийгээд ямар хүндрэлтэй асуудал байна гэдгийг нь судалж үзсэний үндсэн дээр

энэ 6 дугаар зүйлүүд орж ирж байгаа юм.

Алслагдсан 3 дүүрэг дээр бол нэлээдгүй асуудал байдаг. Яг агентлагууд дээр Багануур, Налайх, Багахангай дээр бол асуудлууд ярьдаг. Гэхдээ өнөөдөр оруулж ирж байгаа хуулиуд дээр энэ алслагдсан 3 дүүрэг хамаарахгүй. Энэ аймгуудад, 21 аймагтай хамааралтай зохицуулалт орж ирж байгаа, сумуудтай хамааралтай.

Д.Тогтохсүрэн: Яах вэ ээ дараагийн хэлэлцүүлгээс санал яригдах байх. Тодруулга бий юу, үгүй юу, үг хэлэх юм уу дараагийнх дээр нь? Гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж үг хэлэх гишүүд байвал нэрс авъя.

Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Раднаасэд гишүүн. Төрийн хэмнэлтийн хууль. Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Зуд турхан дөнгөж эхэлж байгаа. Одоо энэ 2, 3 сард маш хүндэрнэ. Энэ бензин тос, машин техник гээд яах вэ дээ тэгээд л явах нь зөв л байх. Одоо энэ Орон нутгийн хөгжил сангийн хөрөнгө гэж маш их хэмжээний мөнгө байгаа. Ойролцоогоор одоо хэд байна энэ жилийн хувьд? Бид нар чинь энэ Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгийг заавал зураг, төсөвтэй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд зарцуулна, иргэдийн эрэмбээр өгөх яасан юунд өгнө гээд ингээд хуулийн үгтэй. Энэ жил бол нийтдээ ер нь хэчнээн сум энэ хавар хүндрэхээр байна? Энэ Онцгой комисс дээр тооцоо байгаа юу? Нийт 330 сумын хэд нь хүндрэхээр байна? Энэ Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг энэ өвс, тэжээлийн юунд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр тухайн аймаг, сумд нь эрх олгох хэлбэртэй ийм зохицуулалт хийж болох уу?

Энэ хавар нөөцөөс маш их хэмжээний мөнгө гарна. Энэ алслагдсан аймаг, сумдад бид нар өвс тэжээл очиход тун хүнд шүү. Хаанаас яаж авч очих вэ, яаж оруулах вэ гээд. Тэр бол эргэн төлөгдөх нөхцөлтэй учраас тухайн сумынх нь бизнес эрхэлдэг хүмүүс нь байна уу, малчид нь байна уу нийлээд нэгдээд тэр хөрөнгийг нь зарцуулах эрхийг нь ямар хэмжээнд байдаг юм тодорхой хяналттай, тайлагналтай явуулаад гаргах юм бол илүү үр дүнтэй юм болов уу л гэж бодох юм. Энэ дээр Улсын онцгой комисс дээр тодорхой тооцоо судалгаа, материалууд байна уу? Энэ өнөөдөр бид нар машин техник, бензин тос, хувцас хунар гээд энэ яах вэ наад талын л юм л даа. Гол агуулга, цаад гүн рүү нь орж бид нар чадахгүй. 2 сард чуулган байхгүй, 3 сард чуулган байхгүй, 2, 3 сар эд хүндэрнэ. Хамгийн их хүндрэх үе чинь тэр үе. Тэгэхээр түүн дээр би бол их томоор нь л энэ мөнгө төгрөгийг нь ахиухан шийдчихмээр аймаг, орон нутагт дэмжвэл дэмжих, дэмжихгүй. Энэ 6, 7 сард энэ хот нь харлачихсан айлууд бүгд төв рүү шилжинэ шүү.

Д.Тогтохсүрэн: Раднаасэд гишүүн асуулт асуулаа. Амарсайхан сайд хариулт өгнө. Амарсайхан сайдын микрофон.

С.Амарсайхан: Өвөлжилт амаргүй байгаа хүндэрч байгаа, цаашидаа улам хүндэрнэ. Цаана нь хаврын урт өдрүүд үргэлжилнэ. Өнөөдрийн байдлаар нийтдээ 8 аймгийн бараг хориод сум төмөр зудтай байна. Өөрөөр хэлэх юм бол 44 оны мичин жилийн зуд гэж манай монголчууд, өвөг дээдэс, ахмадууд ярьдаг байсан тэр хэмжээнд хүрсэн гэдгийг манай малчид ярьж байгаа, бид биш.

Дээрээс нь цаг уурын байгууллага тодорхойлж байгаа.Түүнээс гадна дахиад нийтдээ 100 орчим сум цагаан зудтай байна. 20 гаруй аймгийн. Ингэхээр нийт улсын хэмжээнд бараг 120, 30 сум хүндрэлтэй нөхцөл байдалд орсон. Энэ жил бол нийт Монгол орны бараг 90 орчим хувь цасан бүрхүүлтэй

болсон. Цас, мөс, нойтон цас, бороо гээд энэ цас хатуурч, мөстөхийг шилэн зуд гэж яриад байгаа юм, төмөр зуд гээд. Мал бэлчих боломжгүй, бэлчээрийн даац хэтэрсэн, отор нүүдлээр маш олон аж ахуй аймаг, орон нутгаар явж байгаа.

Жишээ нь өнөөдрийн байдлаар зүүн аймаг тэгэхэд 60 орчим мянган мал отор нүүдлээр явж байна. Явуулын штабыг Улсын онцгой комиссоос байгуулсан Улсын онцгой комисс дээр байнгын 24 цагийн ажиллагаатай штабыг байгуулж Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлээд ажиллаж байгаа. Сая Раднаасэд гишүүний хэлсэн асуудалд би үндсэндээ хариулахад хөдөө, орон нутагт амаргүй байгаа, энэ үндсэн асуудал сая яригдаж байгаа Хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг гишүүд ч ярьж байна, зарим саналууд ч гарч байна. Үүнийг бас харгалзаж үзэх ёстой. Ялангуяа аслагдсан сум, багийн хэмжээнд. Сумын Засаг дарга нар нь машин байхгүй, явган таваргадаг. Машин түрээсэл гэдэг 10 мянган төгрөгөөр 10 км-ийн явж чадахгүй. Гэтэл цаана нь баг сумын малчид нь хэдэн 100 км-ийн цаана байж байдаг. Амьдралгүй ийм шийдвэрүүд бас байгаа.

Дээрээс нь энэ Төсвийн хэмнэлтийн тухай хуулиар зарим байгууллагуудын тусгай чиг үүргийн мэргэжлийн байгууллагуудын хэмнэлт, урсгал зардлыг хэмнэсэн. Үүнээс үүдээд эмнэлгийн шинжилгээ, оношилгоо, хүнсний бүтээгдэхүүнүүдийн хими, цацраг, нян, бактерийн шинжилгээнүүд зохих хэмжээнд хийж чадахаа больсон. Үүнээс үүдээд эрүүл мэнд, амь настай холбоотой асуудлууд хүндрэх эрсдэлт нөхцөл байдал бий гээд тоочоод байвал маш олон асуудлууд бий. Үүнийг Засгийн газрын хуралдаан дээр бид бас нэмж оруулаарай гэдэг үүрэг, даалгавар өгөгдсөн. Энэ зарим нь ороогүй байх шиг байна.

Ер нь энэ орон нутгийн байгууллагуудыг бид төсвийн бие даасан үйл ажиллагааны бие даасан, өрсөлдөх чадвартай, цаашидаа бүсчилсэн маягаар явуулна гээд эхнээсээ авхуулаад бүсчилсэн хөгжлийн бодлого, бүр цаашилах юм бол сонгуулийн тойргоо бүсчилсэн маягаар явуулж байгаа.

Тэгэхээр тодорхой хэмжээнд энэ орон нутагт асуудлуудаа шийддэг, бичиг цаас авахад төвөөс, Засгийн газрын шийдвэр, Улсын Их Хурлаас тогтоол гардаг, машин бензин шатахууныхаа асуудлыг шийдэхээр Их Хурал дээр хууль баталдаг байж болохгүй шүү дээ. Эрх үүргийнх нь хүрээнд яагаад бидэнд Үндэсний аудитын газар гэж байгаа билээ, дотоод аудит байгууллага гэж байдаг билээ. Аймаг, нийслэл, дүүргийн аудитын газрууд гэж байдаг билээ. Иймэрхүү асуудлуудаа бид бас аль аль талаасаа харж энэ хуулийг эцэслэн батлахдаа анхаарах ёстой зүйлүүд байгаа гэж бодож байгаа.

Д.Тогтохсүрэн: Уул нь хариулт байхгүй байсан юм байна шүү дээ. Энэ чинь үг байсан юм байна. Сандаг-Очир гишүүн үг хэлнэ.

Ц.Сандаг-Очир: Би 6.5.21 дээр нийслэлээс алслагдсан аймгийн, дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар гэж аж ахуйн нэгж зарчмын зөрүүтэй санал оруулна. Та бүхэн маань бас дэмжиж өгөөрэй. Ер нь алсын 3 дүүрэг хэцүү байдаг. Энэ халамж газар, даатгал, аудит гээд л. Ингээд л нийслэл дууддаг одоо 3 цагт цугла, 2 цагт цугла гээд. Тэр муу машинууд нь чааваас даа хамгийн муу машинууд л байдаг юм. Хамгийн эрсдэлтэй нөхцөлд төрийн ажил, үйлчилгээ гүйцэтгэж яваа шүү. Ер нь тэр дундаа энэ өвөл халтиргаа, гулгаатай үед яаж давхидаг билээ. 1 өдрийнхөө ажлыг алддаг үндсэндээ. Маш эрсдэлтэй замаар ирж, очдог төрийн ажлыг. Нийслэлийн агентлаг дуудна, харьяа дээд газрууд

дуудна. Тэгээд л дуудагдах газрууд олон бий.

Тийм учраас энэ алсын 3 дүүргийн онцлогийг харгалзаж цаашидаа бас энэ хууль юман дээрээ бас оруулж ирэх шаардлага гарвал ялгаатай онцлог байдлыг нь авч үзэж байгаарай л гэж хэлье. Хэлэлцүүлгийн шатад сая хуралдаан даргалагчтай ярилаа зарчмын зөрүүтэй санал гаргая гэж ингэж бодож байна. Баярлалаа.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Сандаг-Очир гишүүн санал хэллээ, үг хэллээ. Батжаргал гишүүн ч бас түрүүн санал хэлсэн. Аймгуудыг ялгаварлаж болохгүй гэсэн, сая бас Сандагаа гишүүн алслагдсаныг оруулах ёстой гэж байгаа эдгээрийг дараагийн хэлэлцүүлэг дээр авч үзэх ёстой байх гэж бодож байна.

Ингээд санал хураалт явуулъя. Гишүүд үг хэлж дууслаа.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжье гэснээр санал хураалт явуулъя. Гишүүд ээ анхаараарай. Хэлэлцэх эсэхийг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. дэмжье.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 81.8 хувь нь хуулийн төслийг дэмжсэн байна.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор танилцуулна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

11.48 цаг

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж эхэлье.

Төсөл, хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Борхүүгийн Дэлгэрсайхан танилцуулна. Дэлгэрсайхан даргыг урьж байна.

Б.Дэлгэрсайхан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хот 2022 оны байдлаар Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 65 хувийг дангаараа үйлдвэрлэж байгаа бөгөөд хотын төсвийн 90.1 хувийг татварын орлогоор, 9.9 хувийг татварын бус орлогоор бүрдүүлж байна. Төсөв дагасан уг санхүүгийн схемийг шинэчлэн олон улсын жишиг хотуудын эдийн засгийн хөгжилтэй ижил түвшинд хүргэх нэг чухал алхам бол хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох томоохон төслүүдийн санхүүжилтийг шийдвэрлэх механизм юм.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлд орон нутгийн болон ногоон бонд зэрэг нийгмийн байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх хөрөнгө оруулагчид хангалтгүй байгаа бөгөөд нийслэлийн үнэт цаасны хувьд гол сонирхож буй субъект нь арилжааны банкнууд болж байна. Арилжааны банкнуудын хувьд аль болох өгөөж өндөртэй өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхолтой байна.

Иймд нийслэлийн хэмжээний томоохон төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын хямд эх үүсвэрээр зөвхөн дотоодын зах зээлээс босгох зах зээл хязгаарлагдмал байна.

Нөгөө талаар олон улсын зах зээл дээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлын багасгах чиглэлээр дэлхийн улс орнууд далайцтай арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Үүний нэг нь ногоон санхүүжилтийг хөгжүүлэх явдал бөгөөд хөгжингүй улс орнууд ихээхэн хэмжээний хөрөнгийг энэ чиглэлийн хөрөнгө оруулалтад зориулах чиг хандлага дэлхий даяараа эрчимжиж байна. Түүнчлэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн ногоон зээл болон бондын хүү бага бөгөөд 2023 оны 4 дүгээр сарын Олон улсын валютын сангийн судалгаанаас үзэхэд хөгжиж буй орнуудын хувьд ногоон зээл, энгийн бондын хүүгийн түвшний зөрүү 2 хувь орчим байна.

Иймд дээрх хэрэгцээ, шаардлагыг үндэслэн нийслэл олон улсын зах зээлд үнэт цаас гаргах боломжийг бүрдүүлэх зорилгоор Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсрууллаа.

Нийслэлийн үнэт цаасыг олон улсын зах зээлд гаргах эрх зүйн орчныг бий болгосноор урт хугацааны, зардал багатай өрийн хэрэгслийг зах зээлд гаргах, үүний үр дүнд төсөвт ирэх ачааллыг бууруулж, нийслэл хөгжлийн болон томоохон төслүүдийг санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэх, цаашилаад Монгол Улсын валютын нөөц бүрдүүлэлтэд төгрөгийн ханишийн чангаралт, гадаадын хөрөнгө оруулалтад эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Нийслэл нь олон улсын зах зээлд үнэт цаас гаргах боломжтой болсонтой холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан бөгөөд төсөлд нийслэл нь Засгийн газар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн нэгэн адил дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл,

банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авахтай холбогдуулан үйлчилгээ худалдан авах харилцаанд тус хууль хамаарахгүй байхаар нэмж тусгасан.

Түүнчлэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих “Сэлбэ дэд төв” төсөлд түшиглэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар гаргах, нийслэлийн гадаад үнэт цаас зориулж 2024 оны төсвийн жилд Засгийн газрын өрийн баталгаа гаргах Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Баярлалаа.

Д.Тогтохсүрэн: Дэлгэрсайхан сайдад баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Борхүүгийн Дэлгэрсайхан Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн Монгол Улсын сайд, Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Пүрэвийн Сайнзориг Нийслэлийн Засаг даргын, Номинчимэг юм уу? Одсүрэнгийн Номинчимэг Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын хариуцсан орлогч, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Тулга нь байна уу? Дорждэрэмийн Цолмон Нийслэлийн Засаг даргын Захиргаа, хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх? Ирээгүй байна. Дугаржавын Амгалан Нийслэлийн Засаг

даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга, Лхагвадоржийн Эрдэнэбадрах Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн өрийн удирдлагын тасгийн дарга байна уу? Маньбазарын Говьсайхан Нийслэлийн орон сууцын корпорацын гүйцэтгэх захирал гэсэн ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Хуулийн төслүүдтэй холбогдуулж асуух асуулт гишүүд байна уу? Нэрс авъя асуух асуулт.

Өнөрболор гишүүнээр тасаллаа. Миний нэр байх ёстой. Энэ яагаад орохгүй байгаа юм? Би иүүд орчих юм уу? Өнөрболор гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Үнэхээрийн энэ нийслэл хотын түгжрэлийг бууруулах, агаар орчны бохирдлыг бууруулах чиглэл дээр энэ нэгэнт бий болчихсон инженерийн шугам сүлжээ, дэд төвүүдээ түшиглэж орон сууцжуулалтын асуудлыг шийдэх, энэ замынхаа нэвтрэх чадвар, бас шинэ технологиудыг нэвтрүүлэх чиглэл дээр бид онцгой анхаарч ажиллах ёстой. Үүнийг дэмжиж байгаа юм гэж.

Харин яг бэлэн хийгдчихсэн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсвүүд нь ер нь хэр байна вэ гэдэг асуудал дээр нэг хариулт авмаар байна.

Хоёр дахь зүйл энэ гарч байгаа бондуудыг үндсэндээ арилжааны банкнуудад төвлөрүүлэх л ийм л бодлого л яваад байх шиг байна л даа. Энэ мэдээлэл юмнаас нь сонсохоор зэрэг. Тэгэхээр Засгийн газрын гэдэг юм уу, энэ орон нутгийн бондууд ахиу гарах тэрийг нь энэ банк, санхүүгийн салбарынхан авчхаад байх юм бол бодит эдийн засгаа дэмждэг мөнгөний урсгал, нийлүүлэлт багасах учиртай. Багасчихна.

Тэгэхээр зэрэг үүнд тодорхой бас хязгаар юмнууд тогтоож өгөхгүй бол эдийн засгийн бусад салбарууд, энэ бодит салбарууд чинь өөрсдийнхөө үйл ажиллагааг явуулах, өргөтгөх, хямд өртөгтэй эх үүсвэрийн дутагдалд орно. Үүнээс болж эдийн засагт бас нэлээн тодорхой хүндрэлүүдийг авчирна гэж ингэж л ойлгоод байна л даа. Тийм учраас энэ гаргах гэж байгаа бондын хязгаар юмнууд гэж байна уу? Ямар тооцоолол төсөөлөл байна вэ? Ийм зүйл дээр хариулт авъя.

Д.Тогтохсүрэн: Батжаргал гишүүн асуулт асуусан. Ажлын хэсгийн 2 номер Нямбаатар дарга хариулт өгнө. 2 номерын микрофон.

Х.Нямбаатар: Баярлалаа. Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Бид ерөөсөө энэ нийслэл гадаад бонд гаргаж энэ “Сэлбэ дэд төв”-ийг санхүүжүүлж, Баянхошуу дэд төвийг үргэлжлүүлж л гэдэг л ийм. Өөрөөр хэлбэл энэ 2024 оны барилгын улиралд бид нар 20 орчим мянган айлын орон сууцын иж бүрэн хороолол барих, түүгээрээ дамжуулж тухайн орон сууцын иж бүрэн хороолол дунд нийгмийн болон соёлын ажлын байр зэргийг бүхэлд нь яг олон улсын стандартын дагуу төвлөрлийг сааруулах чиглэлээр ийм бүтээн байгуулалтын ажлуудыг хийе гэж байгаа. Энэ дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнүүд батлагдсан. Ажлын зураг, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах тендерийн богино лист үүсчихсэн байгаа.

Энэ богино лист дотроосоо бид нар сонгон шалгаруулалтаа хийгээд энэ 3 сарын сүүл гэхэд бид нар энэ “Сэлбэ дэд төв”-ийн ажлын зургийг эхнээсээ гар дээрээ авна гэсэн ийм тооцоотой ажиллаж байгаа. Сая 12 сард батлагдсан хуулийн дагуу “Сэлбэ дэд төв” дээр 2003 айлын нэгж талбарыг чөлөөлөх ажлын хэсэг гараад хэлэлцээрийн баг энэ хойд талдаа

байрлаад иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай хэлэлцээр хийх ажлууд эхнээсээ эхэлж байгаа. Бид нар нийслэлийн төсөв дээр энэ 2003 нэгж талбарыг чөлөөлөхтэй холбоотой тодорхой зардлуудыг нүүлгэн шилжүүлэх болон түрээсийн орон сууцад оруулах, бэлэн орон сууц худалдаж авахтай холбоотой санхүүжилтийнхээ эх үүсвэрийг төсөв дээрээ тавьсан явж байгаа. Ингээд 3 сарын сүүл гэхэд бид нар ерөнхийдөө ажлын зургаа хүлээгээд авчихна.

Үүнээс өмнө олон улсын зах зээл дээр энэ бонд гаргах ажлаа эхлүүлнэ. Зүгээр гадаад бонд гаргах гээд байгаагийн гол агуулга нь Батжаргал гишүүн ээ энэ манай барилгын үйлдвэрлэлийн дийлэнх нь барилгын бараа, материал болж ханиид тийм дарамт үзүүлж болзошгүй гэдэг үүднээс бид нар гадаад зах зээл дээр бонд гаргая гэдэг ийм агуулгаар ажиллаж байгаа.

Дотоодын зах зээл дээр бонд гаргах бүх шийдвэрүүд бид нарт бэлэн байгаа. Энэ дотоодын зах зээл дээрээс оны өмнө 10 сарын дундуур бонд гаргахад 17.5 хувьтай бонд гарахаар байсан. Бид нар сая оны өмнө Засгийн газар Америкийн Нэгдсэн Улсад бондын арилжаанд оролцоход бондын манай захиалга 13 дахин давахаас гадна 1 бондын Засгийн газрын үнэт цаас 7.48 хувьтай гарсан ийм зүйл байгаа. Бид нар үүнээс хойш бас манай гадаад бонд дээр ажиллаж байсан гаднын зөвлөхүүдтэй ажиллахаар Засгийн газрын баталгаатай Монгол Улсын дотоод орон нутгийн бондыг худалдаж авах сонирхол хөрөнгө оруулагчдад их байна гэдэг ийм зүйл байгаа.

Дээр нь сая хууль санаачлагчийн илтгэлд танилцуулсан танилцуулгад дурдагдсан зүйл бид нар аль болох энэ төслөө хүлэмжийн хийг бууруулах, ногоон өнгөтэй байх энэ чиглэл рүүгээ техник эдийн засгийн үндэслэл, зураг, төсвөө боловсруулж байгаа гэдгийг эцэст нь хэлье.

Д.Тогтохсүрэн: Болсон гэж үзэж байна тээ? Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Гишүүдийн өглөөний мэндийг хүргэе. Энэ Өрийн удирдлагын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар орж ирж байгаа энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа юм.

Гэхдээ хэд хэдэн бас асуудлууд байхыг бас онцгой анхаарах ёстой гэж бодож байна. Нийслэлийн удирдлагууд энэ агаар, орчны бохирдол, түгжрэлийн асуудлаар бол шийдэл гаргахаар чиглэлээр ажлууд эрчимжээд явж байна. Улсын Их Хурал болон Засгийн газар нийслэлээс оруулж ирж байгаа бас энэ асуудлуудыг шийдвэрлэж дэмжлэг үзүүлэх тал дээр иуурхай бас ажиллаж байгаа гэдгийг бас хэлье.

Энэ өнгөрсөн хугацаанд ер нь Өрийн удирдлагын хуульд 15 оноос хойш ер нь 10 дахь удаагаа ер нь өөрчлөлт оруулахаар орж ирж байгаа юм байна. Энэ хуулийн өөрчлөлтийн хүрээнд ер нь яг ямар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа вэ гэдгийнхээ талаар бас тайлбарлавал зүгээр байна. Яг ямар арга замаар хэрэгжүүлэх вэ гээд. Өнгөрсөн хугацаанд энэ хэрэгжих боломжгүй нөхцөл байдал энэ сонгуулийн мөчлөг дамжаад хэрэгжээгүй ч юм уу, эсвэл янз бүрийн асуудлуудаас болоод энэ асуудлууд шийдэгддэггүй явж ирсэн. Энэ асуудлуудаа олон нийтэд энэ төсөл, хөтөлбөрөө бол нээлттэй болгох, ил тод болгох, хариуцлагатай байх тал дээр бол бас онцгойлон анхаарах ёстой гэж бас хэлмээр байна.

Нөгөөтээгүүр энэ Засгийн газраас баталгаа гаргах тохиолдолд үүсэх эрсдэлийг маш сайн тооцох ёстой байна. Энэ улсын нийт өр 100 гаруй их наяд төгрөг байгаа. Сүүлийн 30-аад жилийн хугацаанд төр 366 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн юм байна лээ. Санхүүжүүлэх зориулалтаар 8.5 тэрбум ам.долларын ээл авсан. Үүнээс 5.7 нь төсөл, хөтөлбөрт хэрэгжүүлсэн, 2.7 нь

төсвийн дэмжлэгт авч ашигласан юм байна. Энэ үлдэгдэл болох 20.1 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа энэ байгаа юм байна. Энэ миний ойлгосноор үндсэндээ бол энэ өрийн тааз, энэ үлдэж байгаа орон зай бол 1 тэрбум долларын л орон зай үлдэж байна гэж бол өмнө нь ойлгосон. Яг энэ ийм, уул нь энэ өрийн дарамттай яг энэ валютын хангалттай нөөцгүй бас улс орны эдийн засаг энэ гадаад, дотоод хүчин зүйлээс шалтгаалж байгаа ийм эрсдэлтэй хэвээр байгаа энэ цаг үед уул нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, эрх зүйн таатай орчин бүрдэж явсан бол илүү их сайхан дэмжлэг болох байж дээ гэж бас харамсаж сууна. Энэ талаар бас хариулт авъя. Баярлалаа.

Д.Тогтохсүрэн: Ажлын хэсэг Ганбат дарга хариулах юм уу? Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат, ажлын хэсгийн 4 номер. Ажлын хэсгийн 4 номер.

Ж.Ганбат: Өнөрболор гишүүний асуултад хариулъя.

2024 оны төсвийн тухай хууль Улсын Их Хурлаар батлагдаад хэрэгжиж байгаа. Энэ Улсын Их Хурлаар батлагдсан Төсвийн тухай хууль дээр Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээг 3.5 их наяд төгрөг байна гээд заасан байгаа. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байна гээд өрийн дээд хязгаар байгаа. Бид энэ дээд хязгаарыг хүрээнд л үйл ажиллагаа явуулж байгаа.

Тэгэхээр бид энэ өрийн дээд энэ 60 хувь гэдэг энэ хязгаар дотор бидний сая Улсын Их Хурлаар батлагдсан хууль дээр 3.5 их наядын баталгааны дээд хэмжээг нь баталчхаад ингээд энэ хотын гаргах гэж байгаа бондыг энэ хүрээндээ л бид яг батлагдсан энэ хуулийнхаа хязгаарын хүрээнд авч хэрэгжүүлэх юм.

Улсын Их Хурлаас зөвшөөрлөө авсны дараа Засгийн газар дотроо тэр Өрийн удирдлагын тухай хуульд заасан бусад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагыг нь хангаж байгаа эсэхэд хяналт тавиад, үүний шаардлагыг нь хангуулаад энэ ажил цаашаа явах бүрэн бололцоотой юм.

Д.Тогтохсүрэн: Болчихсон уу? Тэр нийслэлийн, энэ хүрээндээ ийм юм асуугаад байна хэн хариулах юм? Нямбаатар сайд хариулах юм уу? Энэ Өрийн удирдлагын хуульд өөрчлөлт оруулаад гаргаж байгаа энэ бондын мөнгөөр юу юу шийдэх гэж байгаа юм бэ гэж асуугаад байна шүү дээ. Гол нь ямар арга хэмжээнүүд шийдэх гээд байгаа юм бэ гэж. Тийм, ямар арга замаар, ямар ажил хийх гээд байгаа юм бэ гэдгийг л асуугаад байна.

Ажлын хэсгийн 3 номер Нямбаатар дарга. Ажлын хэсгийн 2 номер Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би Өнөрболор гишүүний асуултад маш товчхон хариулъя. Бид нар энэ жил 20 мянган айлын орон сууцын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх гэж байгаа. Би маш товчхондоо нэрлэвэл одоо бид нар энэ Улаанбаатар хотын төв талбайгаас хойшоо 1.7 км-ийн зайд байгаа “Сэлбэ дэд төв” гээд ус, дулаан, цэвэр, бохирынх нь асуудал шийдэгдсэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө нь батлагдсан 160 га дээр төлөвлөлт хийлгээд, ажлын зураг боловсруулах тендер зарлачихсан явж байна. Энд ойролцоогоор 12 мянган айлын орон сууцын хороолол барина. Энэ 12 мянган айлын орон сууцыг бид нар барьж чадах юм бол наашаага 32-ын тойрог хүртэлх 5 буудал, 6 буудал, энэ Дэнжийн мянга орчмын 12 мянган айлыг шууд газрыг нь орон сууцаар своп хийх нөхцөлөөр нүүлгэн шилжүүлэх ийм хуулийг сая хэдүүлээ баталчихсан.

Ингэсэн тохиолдолд энэ 12 мянган айлын нүүлгэн шилжүүлсэн тохиолдолд 701 орчим га газрын газар чөлөөлөлтийн ажлуудыг энэ 2025, 2026 онуудад хийх ийм төлөвлөлттэй. Ингээж чадсан тохиолдолд бид нар Улаанбаатар хотын нийт гэр хорооллын 1/4-ийг төлөвлөлтийн дагуу орон сууц барих ийм боломжтой газар чөлөөлөлт хийгдэж, үүн дээрээ аж ахуйн нэгж байгууллагуудад газрыг төлөвлөлтийн дагуу хуваарилж оролцохгүй бол одоо аж ахуйн нэгжүүдийг зүгээр гэр хорооллыг дахин төлөвлө гээд хэлэхээр 2-3 айлын газар чөлөөлөөд, түүн дээрээ хоёр 9 давхар бариад л төлөвлөлтгүй юм хийгдээд байгаа.

Тийм учраас бид нар энэ нийслэл Улаанбаатар хотыг орон сууцжуулах эхлэлтийн цэгийг “Сэлбэ дэд төв” гэж ойлгож байгаа. Үүнтэй параллель уур амьсгалын өөрчлөлтийн сангийн 95 сая доллар батлагдсан. Үүний дагуу бид нар Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт бусад эх үүсвэрүүдтэйгээ хамт 6 мянган айлын орон сууц, одоо 200 нь баригдаж дуусаж байгаа. Цаашид үргэлжлүүлээд бид нар 6 мянган айлын орон сууцын төслийг бас тэнд үргэлжлүүлэхээр тэнд зураг, төсөв нь хийгдчихсэн, дэд бүтэц нь татагдсан байгаа.

Үүнтэй зэрэгцээд Шар хадан дээр 200 айлын орон сууц тийм ээ, Шар хад дэд төв дээр. Наад талд энэ Улаанбаатар хотын ашиглалтын шаардлага хангахгүй дээр бас Нийслэлийн орон сууцын корпорацыг хэрэгжүүлэх хэд хэдэн төслүүд нийлээд энэ 2024 оны барилгын улиралд бид нар 20 мянга орчим айлын орон сууцын ийм хорооллыг барьж байгуулах, иж бүрэн хороолол барьж байгуулах ажил хийгдэнэ. Энэ бид нар гадаад бонд босгож байгаа юугаараа яг эх үүсвэр дутагдаж байгаа “Сэлбэ дэд төв” дээрээ ажлаа эхлүүлэе гэж байгаа юм. Энэ “Сэлбэ дэд төв”-ийг л бид нар барьж чадвал ойр орчмынх нь гэр хорооллын айлуудыг нүүлгэн шилжүүлж

ороод, төлөвлөлт хийгээд ,том газар чөлөөлөлт хийгээд түүн дээрээ барилгын компаниудыг 50, 100 га-аар нь бид нар тодорхой нөхцөлтэйгөөр өгч энэ бонддоо зарцуулсан мөнгөө эргэн босгох ийм л төлөвлөлттэй ажиглаж байгаа.

Д.Тогтохсүрэн: Болчихсон гэж ойлголоо?

Би нэг зүйл тодруулъя. Ганбат дарга хариулах уу? Ганбат дарга хариулах байхдаа би Засгийн газраас гол нь асуух гээд байгаа юм.

Тэгэхээр энэ Өрийн удирдлагын тухай хуульд энэ 28 дугаар зүйл дээр л өөрчлөлт орж ирж байгаа юм байна л даа. Өмнө нь нийслэлд өрийн баталгаа гаргаж болно гэдэг ийм заалт байсан. Энэ 28.1. Энэ дээр гол нь гадаад үнэт цаасыг гэдэг үг гол нь нэмэгдэж орж ирж байгаа юм.

Тэгэхээр энэ 28 дугаар зүйлийн 1 дүгээр тавьсан хамгийн, 28 дугаар зүйлийн 3-д тавьсан хамгийн гол юм бол 5 шаардлага байгаа юм Ганбат даргаа. Энэ 5 шаардлагыг энэ орж ирж байгаа төсөл хангаж байгаа юу гэдэг асуудал асуух гэж байгаа юм. Нэгдүгээрт 4 шаардлага. Нэгдүгээрт, төсөвтэй байх, төсөвт тусгагдсан байх.

Хоёрт, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх.

Гуравдугаарт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагчигдсан байх.

Дөрөвдүгээрт, Тухайн төслийн төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник эдийн засгийн үндэслэл хийж баталгаажсан байх гэдэг ийм 4 шаардлагыг хангасан байна гэж энэ хуульд заачихсан. Энэ шаардлагыг хангасан зүйлийг Их Хурал хэлэлцэх ёстой.

Тэгэхээр би нэгдүгээрт Ганбаатар даргаас үүнийг асуух гэж байгаа юм.

Хоёрдугаарт нь Нямбаатар даргаас асуух гэж байгаа юм. Таны саяын хэлж байгаа 20 мянган айлын орон сууцны газар чөлөөлөлт болон барилгажилтын ажил хийхэд нийт ямар хэмжээний зардал, төсөв шаардагдаж байгаа юм бэ? Үүнийг бүгдийг нь энэ гадаадаас гадаад үнэт цаасны буюу үндсэндээ энэ Засгийн газраас өрийн баталгаа гаргаж гаргуулж байгаа байхгүй юу. Үүнийг дагасан тогтоол нь өрийн баталгааны тогтоол байгаа. Энэ өрийн баталгаагаар хийнэ гэж байгаа юм. Энэ яг ямар хэмжээний мөнгө гарах гэж байгаа юм бэ? Бид чинь бол төсвийн хүрээний мэдэгдэл түрүүн яг Өнөрболор гишүүн хэлж байна лээ. 1 орчим тэрбум доллар буюу 3.5 орчим их наяд төгрөгийн л орон зай бий. Үүний 500 сая орчим, 500 тэрбум орчим дээр нь бид нар өмнө нь шийдвэр гаргачихсан улсын төсөв батлах үед энэ Дорнодын станц өөр хаанах ч билээ дээ эрчим хүчтэй холбоотой хоёр асуудал дээр гаргасан. Тийм, Чойбалсангийн дулааны станц, газрын тосны бүтээгдэхүүн хоёр дээр гаргасан юм. Одоо тэгэхээр үлдэж байгаа 3 орчим их наяд төгрөг байна л гэсэн үг байхгүй юу. Эндээс ямар хэмжээний юм нь энд зарцуулах гээд байгаа юм бэ гэдэг л ийм л зүйлийг би хоёрдугаарт Нямбаатар сайдаас тодруулъя гэж бодож байна.

Ажлын хэсгийн 4 номер Ганбат дарга.

Ж.Ганбат: Асуултад хариулъя. Энэ өрийг уг нь бид би сая тэр өмнөх хариулт дээрээ бас уг нь дурдсан юм. Төсвийн тухай энэ 24 оны төсвийн хууль батлагдахад Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээг 3.5 их наядар баталчихсан. Энэ хүрээн дотроо л бид нэгдүгээрт энэ төсвийн баталсан төсвийнхөө хүрээнд л энэ асуудлыг авч үзэж байгаа юм.

Хоёр дахь нь Өрийн удирдлагын тухай хуулийг бид нар дээд хязгаарыг хэтрэхгүй байх ёстой. Энэ 60 хувь гэдэг хязгаарыг бид нар дунд хугацаандаа өөрөөр хэлбэл яг энэ дээд хязгаараасаа бид нар дутуу 47.8 хувьдаа одоо явж байгаа. Бид нар энэ 47.8, 60 гээд байх орон зай байгаа. Тэгэхээр Засгийн газраас бид Сангийн яам бол яг энэ Улсын Их Хурлаар батлагдсан саяын энэ дурдсан төсвийн тогтвортой байдлын бүх шалгуур, төсвийн хүрээний мэдэгдэл энэ тэр дээр бүгдэд нь нийцэж байгаа. Яг энэ хүрээндээ л бид нар авч үзэж байгаа. Яг энэ Улсын Их Хурлаас зөвшөөрөл авсны дараа саяын таны дурдсанаас гадна дахиад Засгийн газрын 34 дүгээр зүйл дээр нь Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагчид тавигдах шаардлага гэж байгаа юм. Энэ шаардлагуудыг бас бүрэн хангуулж, засаг дээрээ энэ асуудлыг шийдвэрлэх бүрэн бололцоотой гэж л ингэж л үзээд байгаа юм. Саяын таны хэлсэн 4, 5 шаардлагуудыг хангуулж байгаа.

Д.Тогтохсүрэн: Ажлын хэсгийн 2 номер, Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Тогтохсүрэн даргын асуултад хариулахад энэ бид нар шууд энэ хууль батлагдаад, энэ тогтоол батлагдсанаараа шууд гадаад бонд гаргах гэж байгаа зүйл огт биш. Өрийн удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг хангасны дараа Засгийн газар 2024 оны батлагдсан Төсвийн тухай хуулийн хүрээнд нийслэлд хэдий хэмжээний орон зай дээр бонд гаргах вэ гэдэг эрхийг л тусад нь дараа нь шийдвэр болгож өгнө. Их Хурлын тогтоолыг дагуулж батлуулж байгаа явдал нь нийт дүнгээр нь батлуулаад, энэ чуулган завсарлах гэж байгаа учраас 3 сарын 15-наас өмнө энэ өрийн удирдлагатай холбоотой харилцаанууд үүсэж болзошгүй. Энэ тохиолдолд засаг дээрээ тухай бүрд нь саяын Ганбаа даргын хэлсэн энэ хүрээнд шийдвэрээ гаргаж явъя гэж байгаа.

Таны асуусан би дараагийн нэг асуултад хариулъя. Энэ ер нь энэ “Сэлбэ дэд төв” чинь ямархуу өртгөөр босох юм бэ, үүнтэй холбоотой санхүүжилтийн эх үүсвэрээ энэ гадаад бондоос 100 хувь санхүүжүүлэх гэж байна уу гэдэг ийм асуултыг асуусан. Тэгэхээр газар чөлөөлөлтийн яг өнөөгийн батлагдсан жишиг, тарифын дагуу бүхэлд нь энэ 2003 нэгж талбарыг чөлөөлөөд авах юм бол 400 орчим тэрбум төгрөг байгаа. Бид нар ийм эх үүсвэр гаргалгүйгээр аж ахуйн нэгж байгууллага, иргэддээ одоогийн батлагдсан Улаанбаатар хотыг орон сууцжуулах, Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах хуулийн хүрээнд 4, 5 арга хэрэглүүрээр хэлэлцээр эхлэх гэж байгаа юм. Үүнд:

Нэгдүгээрт, Түрээсийн орон сууцад оруулах.

Хоёрдугаарт, Үйлчилгээний зориулалттай объектоор своп солилцоо хийх.

Гуравт нь орон сууц бэлэн, Нийслэлийн орон сууцын корпорацын мэдэлд байгаа орон сууцаар солилцох.

Дөрөвдүгээрт нь бэлэн үнийг нь төлж авах гэсэн энэ аргуудыг хэрэглэнэ ээ гэдэг ийм байдалаар манай ажлын хэсэг газрын албан дээр тусдаа бие даасан нэгж “Сэлбэ дэд төв” дээр байгуулагдаад одоо ажиллаж эхэлж байна гэдгийг хэлье.

Өнөөдөр бид нар барилгын жишиг өртгийг тооцож барихдаа ойролцоогоор 1.5-1.4 их наядын хооронд энэ 12 мянган айлын орон сууцын барилгыг барина. Үүнээс гадна хорооллын дундах зам, Сэлбэ голыг тусад нь усны ийм нөөц эх үүсвэр, хиймэл далан байгуулах, бас ийм усны давхар цуг төсөл хэрэгжих юм.

Ингээд төсөл бол ойролцоогоор 1.6 их наяд төгрөгт багтаж баригдана гэсэн ийм байдалтай байж байгаа. Бид нар барилгын өртгийг бууруулах чиглэлээр хуульд заасан бусад

боломжуудыг бас ашиглаж барихаар байгаа. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа санхүүгийн эх үүсвэр бүрэн шийдэгдсэн, зургийн асуудал бүрэн шийдэгдсэн, дээр нь санхүүжилтийн эх үүсвэр бүрэн шийдэгдсэн, газар чөлөөлөлт бүрэн шийдэгдсэн энэ нөхцөлд бид нар 4 сарын сүүлээр гүйцэтгэгчийг нээлттэй сонгон шалгаруулалт хийгдэнэ гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. Гүйцэтгэгч бол дотоодын аж ахуйн нэгжүүд энэ төсөл дээр олон багцрууд болж зарлагдах байх гэж бодож байна.

Д.Тогтохсүрэн: Гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Хууль тогтоолын төслүүдийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Нэрс авъя. Алга байна. Одоо санал хураалт явуулна.

Өргөн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт дэмжье.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 90.8 хувийн саналаар уг төсөл дэмжигдсэн байна.

Хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Өнөөдрийн манай Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал үүгээр өндөрлөж байна. Байнгын хорооны хуралд оролцсон гишүүддээ баярлалаа. Хурлын үйл ажиллагаа өндөрлөж байна.

Маргааш чинь нэгдсэн чуулган 14-өөс байгаа. Нэгдсэн чуулганы дараа бид 17 цагаас хуралдаж, энэ хоёр хуулийн анхны хэлэлцүүлгүүдийг хийнэ. Нөгөөдөр дахиад хэлэлцэнэ. Тийм учраас гишүүдийг хуралдаа цагтаа хариуцлагатай оролцохыг хүсье. Баярлалаа.

12.15 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР